

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2009 ОНЫ 5 ДУГААР САР

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны 5 дугаар сарын байдлаар харуулбал:

Ердийн даатгалын компаниудын хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V
1	Даатгалын нийт хураамж	1,508,145,368.04	2,843,688,725.79	1,782,770,692.46
2	Олгосон нийт нөхөн төлбөр	403,969,016.33	417,448,114.06	439,751,675.38
3	Давхар даатгалд төлсөн хураамж	638,508,028.89	543,281,677.87	386,433,464.28
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	13,586	39,878	16,684
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	43,590,000,000.00	45,803,855,532.00	7,425,600,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	35,335,580.00	50,000,000.00	46,776,886.00

2009 оны 5 дугаар сарын даатгалын хураамжийн орлого 4 дүгээр сарынхаас 38 хувиар буурсан хэдий ч олгосон нөхөн төлбөр 22.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Давхар даатгалд “Миг даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК-иуд 386.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Даатгалын компаниудаас 5 дугаар сард хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Монгол даатгал” ХХК нь “Эм Си Эс Кока Кола” ХХК-ийн ачаа тээврийн даатгалын гэрээний нөхөн төлбөрт олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-III	2009-IV	2009-V
1	Даатгалын нийт хураамж	1,379,750.00	4,555,858.00	1,061,106.00
2	Олгосон нийт нөхөн төлбөр	600,000.00	0.00	0.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	0.00	0.00	0.00
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	5 гэрээ (68 хүн)	3 гэрээ (35 хүн)	6 гэрээ (22 хүн)

5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	50,000,000.00	50,000,000.00	51,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	375,000.00	0.00	0.00

5 дугаар сард “Нэйшнл лайф даатгал” ХХК нийт 51.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий Налайхын эрчим хүчний салбартай байгуулсан 17 хүний “Байгууллагын хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ, 5 хүний “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ байгуулсан байна. Тайлант хугацаанд нөхөн төлбөр гараагүй байна.